

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН НОМЫН САНГИЙН ДҮРЭМ

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Номын сан нь мэргэжилтэн бэлтгэх сургуулийн чиглэлийн дагуу өөрийн болон гадаад орны чухал шаардлагатай ном, сурах бичиг, хичээлийн хэрэглэгдхүүнийг цаг тухайд нь номын фондоо баяжуулдаг сургалт, эрдэм шинжилгээ, соёл гэгээрлийн нэгж мөн. Номын санг номын сангийн зөвлөл заах арга зүйн талаас нь удирдаж, шинэ ном авах, дотоод ажилд хяналт тавьж ажиллана.

Хоёр. НОМЫН САНГИЙН АЖЛЫН ЗОРИЛГО

Профессор, багш, аспирант, магистрант, оюутан, ажилтан багш нарт хэрэгцээт ном сурах бичиг, электрон каталоги, нөөцийн төвийн компьютерээр мэдээллийн үйлчилгээ эрхэлж мэдээлэл түгээнэ. Мэргэжлийн чиглэлийн болон шинэ ном зохиол, сурах бичгийг сурталчлах, ном зүйн лавлагаа өгч шуурхай үйлчилгээ зохион байгуулах зорилготой.

Гурав. УНШИГЧИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ

Тус сургуулийн бүх багш, ажилтан, оюутан, аспирант, магистрантыг сургуулиас олгосон үнэмлэх болон холбогдох бичиг баримтыг үндэслэн уншигчаар бүртгэж ном, мэдээллийн хангамжийн үйлчилгээ үзүүлэнэ. Гадаадын мэргэжилтэн багш, оюутан магистрант, докторант нар болон цагийн багш нарт холбогдох тэнхим салбарын зөвшөөрлөөр уншигчийн карт нээж үйлчилнэ.

Дөрөв. УНШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Уншигч нь номын сангийн ном, сурах бичиг, бусад мэдээллийн үйлчилгээгээр тогтмол үйлчлүүлэх эрхтэй. Уншигч номын сангийн талаархи үйлчилгээ, ном хангамжийн талаархи санал хүсэлтээ номын сангийн зөвлөл, МҮТ-ийн эрхлэгчид илэрхийлж байх эрхтэй.

Уншигч нь номын сангаар үйлчлүүлэхдээ үйлчилгээний картаа шалгуулж, холбогдох бичиг баримттайгаа ирж номын сангийн үйлчилгээний журмын дагуу үйлчлүүлнэ. Номын сан нь багш нарт 10, оюутанд 5 хүртэлх номыг нэг удаагийн олголтоор өгнө. Уншигч нь номын сангаас авсан номыг авахдаа хуудас бүрэн эсэхийг шалган авч, шалгуулан өгч байна.

Уншигч нь ном хэвлэлийг алдаж, үрэгдүүлж, гэмтээсэн тохиолдолд "Алдсан буюу гэмтээсэн ном хэвлэлийг төлүүлэх журам" - ын дагуу төлж, номын санг хохиролгүй болгоно. Уншигч нь өөр газар шилжих, амралт буюу түр хугацаагаар чөлөө авах, ажил, сургуулиас халагдсан тохиолдолд номын сантай заавал тооцоо хийх зэрэг үүргийг хүлээнэ.

Тав. УНШИГЧДАД ҮЙЛЧЛЭХ ЖУРАМ

1. Номын сангийн фондод байгаа ном, сурах бичгийн хангамж, хэрэгцээ, нөөцөөс шалтгаалан гэрээр буюу уншлагын заалаар ном олгож үйлчилнэ.

а/. Ховор цөөн хувьтай ном, лавлах толь бичгүүдийг уншлагын танхимаар

б/. Олон хувьтай ном болон өдөр тутмын хичээлд хэрэглэгдэх сурах бичгүүдийг гэрээр олгож үйлчилнэ.

в/. Уншигч ном аваад тогтоосон хугацаа хэтрүүлсэн тохиолдолд ном авах эрхийг 1-6 сар хүртэл хасна.

2. Хичээлийн жилийн эцэст номын тооцоо хийгээгүй, тойрох зуруулаагүй багшид дахин номоор үйлчлэхгүй эрхийг нь хасна.

Зургаа. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- Уншлагын танхмийн ном хэвлэлийг гадагш авч гарах
- Номын санд хог хаях, тамхи татах
- Номын санд гар утсаар ярьж бусдад саад болох
- Номын санд гадуур хувцас, хүнсний зүйлтэй орох түүнийг идэх, бохь зажлах, ноцолдох болон зүй бусаар авирлах зэргийг хатуу хориглоно.
- Нөөцийн төвийн компьютерийн эд ангиар оролдох, түүн дээр зурах, бичих

Долоо. ЗӨРЧИЛ ГАРГАСАН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- Номын сан, нөөцийн төвөөр үйлчлүүлж буй хэн боловч номын санчийн дээрх журманд заагдсан шаардлагыг хүлээн зөвшөөрч, шаардлагыг хүлээн авах
 - Шаардлага биелүүлээгүй тохиолдолд тухайн багш болон оюутны номын сангаар үйлчлүүлэх эрхийг 1 сараас 1 семестрийн турш хасах буюу гаргасан зөрчилөөс хамааруулж авсан арга хэмжээг МҮТ-ийн эрхлэгчид мэдэгдэх.
 - Техник хэрэгсэл болон бусад эд ангид хохирол гэмтэл гарсан нь баримтаар тогтоогдож тухайн эд ангийг эвдэгч этгээд болон хариуцлага алдсан хэн боловч (багш, оюутан, ажилтан) тухайн үеийн зах зээлийн ханшаар 3 дахин нугалж төлж хохирлыг барагдуулна.